



МОНГОЛ УЛС  
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/9

Чойбалсан

Г Дэмжлэг үзүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.7, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5, “Дорнод аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.2.9, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 18-1/01 тогтоолоор батлагдсан аймгийн 2024 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөний 1.3 дахь заалт, “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 19/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ширээний теннисний ахмадын улсын аварга, Шатрын насанд хүрэгчдийн улсын аварга, Волейболын идэрчүүдийн улсын аварга, Үндэсний сурын харвааны улсын аварга шалгаруулах тэмцээн”-ийг зохион байгуулахад 85,000,000 (наян таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлж, төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

2. Дэмжлэгт шаардагдах 85,000,000 (наян таван сая) төгрөгийг аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 2.53 дахь Ширээний теннисний ахмадын улсын аварга, Шатрын насанд хүрэгчдийн улсын аварга, Волейболын идэрчүүдийн улсын аварга, Үндэсний сурын харвааны улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Бат-Өлзий)-д зөвшөөрсүгэй.


3. Аймгийн Биеийн тамир, спортын газартай байгуулах орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх гэрээг боловсруулан батлуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Э.Эрдэнэбилэг), Санхүү, төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа)-т даалгасугай.

4. Тэмцээнийг чанартай зохион байгуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг олон нийтэд танилцуулж ажиллахыг аймгийн Биеийн тамир, спортын газар (Б.Чимэддорж)-т даалгасугай.

212401104

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ш.Ёл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

Аймгийн Засаг даргын *Д.Н.Н.* оны  
*21...* дугаар сарын *28* -ны өдрийн  
*М.С.З.* дугаар захирамжийн хавсралт



ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ АХМАДЫН УЛСЫН АВАРГА,  
ШАТРЫН НАСАНД ХҮРЭГЧДИЙН УЛСЫН АВАРГА,  
ВОЛЕЙБОЛЫН ИДЭРЧҮҮДИЙН УЛСЫН АВАРГА, ҮНДЭСНИЙ  
СУРЫН ХАРВААНЫ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ДЭМЖЛЭГ  
ҮЗҮҮЛЭХ ЗАРДАЛ

| Д/д      | Хэрэгжүүлэх арга хэмжээ   | Төсөв өртөг<br>(төгрөг) | Шалгуур<br>үзүүлэлт | Хүрэх үр<br>дүн |
|----------|---|-------------------------|---------------------|-----------------|
| 1        | Үндэсний сурын<br>харвааны улсын аварга<br>шалгаруулах тэмцээн    | 20,000,000              | Тамирчдын тоо       | 600             |
| 2        | Волейболын<br>идэрчүүдийн улсын<br>аварга шалгаруулах<br>тэмцээн  | 30,000,000              | Тамирчдын тоо       | 448             |
| 3        | Шатрын насанд<br>хүрэгчдийн улсын аварга<br>шалгаруулах тэмцээн   | 20,000,000              | Тамирчдын тоо       | 32              |
| 4        | Ширээний теннисний<br>ахмадын улсын аварга<br>шалгаруулах тэмцээн | 15,000,000              | Тамирчдын тоо       | 300             |
| НИЙТ ДҮН |   | 85,000,000              |                     |                 |

---oO---